

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

### ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Нийгмийн даатгалын цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн 3 жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/

Материал хүлээн авах:

Хугацаа: 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 08:00 цагаас 02 дугаар сарын 08-ны өдрийн 17:00 цаг хүртэл

Хүлээн авах хаяг: [Songinohairhan@ndaatgal.mn](mailto:Songinohairhan@ndaatgal.mn) цахим шуудангаар хүлээн авна.

Холбоо барих утас: 70173259 88078833

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

БАЙГУУЛЛАГЫН НЭР: СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

д/д	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын		Хариуцах асуудал	Орон тоо	Албан тушаалд тавигдах тусгай шаардлага				
			Ангилал	Нэр			Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Ур чадвар
1	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар	Хамралт, орлогын хэлтэс	Дэс түшмэл ТЗ-6	Хамралт, орлогын хэлтсийн дарга	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр авлага барагдуулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавих, төлөвлөх, тайлагнах, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.	1	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	Эдийн засаг /0311/, Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/ Санхүү, банк, даатгал /0412/, менежмент ба удирдахуй /0413/ эрх зүй /0421/	Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилгот сургалтад хамрагдаж төгссөн байх	Туслах түшмэлийн албан тушаалд 2-с доошгүй жил ажилласан байх	Удирдан зохион байгуулах; Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Манлайлах; Бусад.